



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2019 оны 03 сарын 12 өдөр

Дугаар А/153

Ховд

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай


Монгол улсын Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.3, 38.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2010 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 267 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Жаргалант сумын Цамбагарав багийн нутаг дэвсгэр Ц.Олзвойн 2 дугаар гудамж 204 тоотод байрлах Жужуухайн Цэен-Ойдов /ПЮ60041576/ 2141.0 метр квадрат, гэр бүлийн хэрэгцээний зориулалттай газрыг, газар эзэмших эрх шилжүүлэх гэрээний дагуу Батхүүгийн Бадрахад /ПЭ71063012/ гэр бүлийн хэрэгцээний зориулалтаар 6 жилийн хугацаагаар тус тус эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу шилжүүлж газраа зориулалтын дагуу үр ашигтай, зүй зохистой эзэмшиж, хамгаалж, газар эзэмшүүлэх гэрээнд заасан нөхцөл болзлыг биелүүлж ажиллахыг дээрх иргэн, аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрх нь баталгаажсан иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай газар эзэмшүүлэх гэрээ байгуулж, газар эзэмших эрхийн гэрчилгээ олгон, газрын төлбөрийг хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэн гэрээний биелэлтэнд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Б.Баярсүх/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax-A/153 Ch  
02.00715